



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан томилолтоор ажиллуулах журам”-ын 2.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) болон Азийн хөгжлийн банкнаас хамтран Австрали Улсын Мелбурн хотод зохион байгуулж буй “Азийн бүсийн төрийн өмчит компанийн засаглал” уулзалт, хэлэлцүүлэгт оролцуулахаар Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн А.Молорыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 9-ний өдрийг дуустал албан томилолтоор ажиллуулсугай.

2.Албан томилолтоор ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Албан томилолтоор ажилласан тайланг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн А.Молорт даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

• 132003275

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2025 оны 10 сарын 09-ны
өдрийн А/52 дугаартай тушаалын хавсралт



**“АЗИЙН БҮСИЙН ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ” УУЛЗАЛТАД ОРОЛЦОХ
АЛБАН ТОМИЛОЛТЫН УДИРДАМЖ**

Нэг: Зорилго

“Азийн бүсийн төрийн өмчит компанийн засаглал” уулзалтын хүрээнд Азийн улс орнуудын мэргэжилтнүүдтэй төрийн өмчит компанийн өмчлөл, засаглалын асуудлаар туршлага солилцох, төрийн өмчит компанийн засаглалын бодлогын цар хүрээг үнэлэх, цаашдын хандлага, олон улсын сайн туршлагыг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-аас гаргасан тайлан илтгэл, зөвлөмжийн хүрээнд судлах, Азийн эдийн засаг дахь үр дүнтэй шинэчлэл, түүний зөвлөмжийг хөгжүүлэх, сайн туршлагыг хуваалцахад оршино.

Хоёр: Гүйцэтгэх ажлууд

1. “Австрали Улсын төрийн өмчит компаниуд, төрийн өмчлөлийн туршлагын талаар” семинарт оролцох;
2. “Төрийн өмчит компаниудын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх нь” семинарт оролцох
3. “Төрийн өмчит компани болон хувийн хэвшил хоорондын шударга өрсөлдөөн” семинарт оролцох
4. “Төрийн өмчлөлийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулах талаарх хамгийн сайн туршлагууд” семинарт оролцох
5. “Төрийн өмчит нэгдэл компани, үндэсний баялгийн сан, хөрөнгө оруулалтын компаниудын засаглалыг сайжруулах” семинарт оролцох.